



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

### Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1649 дүгээр захирамж, Газрын ёс зүйн дотоод дүрмийн 1.4, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, албан хаагчдын дунд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдүүлэх, түүнийг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянах, зөрчил гаргасан эсэх, хариуцлага хүлээлгэх асуудлаар эцэслэн дүгнэж шийдвэр гаргах эрх бүхий "Ёс зүйн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ёс зүйн зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, Төрийн албаны Нийслэл дэх салбар зөвлөлд тайлагнаж ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга (О.Оджаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.ТӨМӨРДУЛАМ

9022011029  
8314531 - СБТ17329

1150500045

Газрын даргын 2023 оны ... дүгээр  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
тушаалын хавсралт



## ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хүний нөөц хариуцсан Ахлах мэргэжилтэн

Байгаль орчны стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн

Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:

Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн